



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 5/461

Улаанбаатар хот.

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.6, 27¹.6.3, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.7, 73 дугаар зүйлийн 73.2, 73.2.2, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.7, 37.1.16, 48 дугаар зүйлийн 48.1, 48.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн Татварын хэлтсийн татварын орлогын тасгийн татварын улсын байцаагч Намсрайн Энхтүвшин нь Дундговь аймгийн Татварын хэлтсийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/58 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.18, 10.20 дахь заалтыг зөрчин эрх бүхий албан тушаалтнаас чөлөө авалгүй 4 хоногийн ажил тасалсан зөрчил гаргасан тул тус хэлтсийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 08/501 тоот албан бичгээр ирүүлсэн Ёс зүйн зөвлөлийн дүгнэлт, саналыг харгалзан албан тушаалын цалингийн хэмжээг 6 сарын хугацаатай 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Гаргасан зөрчил дутагдалдаа дүгнэлт хийж цаашид сахилга бат, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллахыг Дундговь аймгийн татварын хэлтсийн татварын орлогын тасгийн татварын улсын байцаагч Н.Энхтүвшинд даалгасугай.

3. Албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах ажлыг зохион байгуулж, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дундговь аймгийн Татварын хэлтэс /М.Туяацэцэг/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Л.Нэргүй /-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД ДЭД ДАРГА



Б.ЗАЯАБАЛ



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 5/16

Мандалговь


Г Б.Эрдэнэхүүд сахилгын шийтгэл Т
ногдуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.2, Хэлтсийн дотоод журмын 10.20 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хэлтсийн жолооч ажилтай Б.Эрдэнэхүү нь төрийн албан хаагчын ёс зүйн зөрчил гаргасан тул үндсэн цалинг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулж сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. Сахилгын шийтгэлийг үндсэн цалингаас тооцож суутгахыг нягтлан бодогч /Н.Долгорсүрэн/-д зөвшөөрсүгэй.
3. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, албан хаагчдад ёс зүйн дүрмийн талаар сургалт зохион байгуулахыг Захиргааны тасаг /Б.Жанчивдорж/-т үүрэг болгосугай.



ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.ТУЯАЦЭЦЭГ